МЭДЭЭ · 2023 оны 7-р сарын 17

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН 5 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2023 оны 7 дугаар сарын 03-наас 07-ны өдрүүдэд хэрэг бүртгэлтийн 29.548, мөрдөн байцаалтын 1734 хэрэгт хяналт тавьж ажиллав.

Үүнээс Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 123, Өмчлөх эрхийн эсрэг 82, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 15, Авлига, албан тушаалын 5, Хүний амьд явахын эсрэг 5, Хүүхдийн эсрэг 4, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 2, нийт 269 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ.

Яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

Нийслэлийн прокурорын газраас иргэн Б.Т нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт химийн хорт болон аюултай бодисын ангилалд орсон 500 кг натрийн сульфидыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, хадгалсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 1, 3-т заасаар яллах дүгнэлт үйлдэн Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын прокурорын газраас тус сумын Нийгмийн даатгалын тасгийн дарга Ж.Э нь албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, нягтлан бодогч Д.Э нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөртөө

давуу байдал бий болгосон гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 23.5 дугаар зүйлийн 1 /Хайнга хандах/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн тус сум дахь Сум дундын шүүхэд;

Говь-Алтай аймгийн прокурорын газраас тус аймгийн Зоонозын өвчин судлалын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Н, Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Б нар нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хураагдсан 10 ширхэг Монгол тарвагыг устгалд оруулсан гэж баримт бичгийг хуурамчаар үйлдэж, хураан авсан эд хөрөнгийг завшсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 21.1 дүгээр зүйлийн 2 /Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах/, 21.10 дугаар зүйлийн 2 /Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх/, 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн тус аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд тус тус шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1563